



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/228

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын 4.7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ДЭМБ-ын зөвлөх ФЕ ВИДА Н.ДИ-ЛИАЧО 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 19-ний өдрүүдэд ЭМҮТ-ны багийн чадавхийг сайжруулах ажлын удирдамж, төсөв”-ийг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтад дурдагдсан зардлыг төсвийн нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. “ДЭМБ-ын зөвлөх ФЕ ВИДА Н.ДИ-ЛИАЧО 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 19-ний өдрүүдэд ажиллах хугацаанд мэргэжилтнүүдийг зөвлөхтэй ажиллах боломжийг бүрдүүлэх, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Бодлогын судалгаа, удирдлагын сургалтын алба /Д.Баттулга/-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН-АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Б. НАРАНТУЯА

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий  
захирлын 2017 оны 12 сарын 13 өдрийн

А/2017 дугаар тушаалын хавсралт

**ДЭМБ-ЫН ЗӨВЛӨХ ФЕ ВИДА Н.ДИ-ЛИАЧО 2017.12.11-19-НИЙ ӨДРҮҮДЭД  
ЭМҮТ-НЫ БАГИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАХ  
АЖЛЫН УДИРДАМЖ, ТӨСӨВ**

**Үндэслэл**

Манай улсад Дэлхийн банкны тусламжтайгаар Монгол улсад Эрүүл Мэндийн Үндэсний Тооцоо (ЭМҮТ) боловсруулж, хөгжүүлэхэд дотоодын чадавхийг бүрдүүлэх чиглэлээр 2002-2005 онуудад Эрүүл Мэндийн Салбарын Төсвийн Зарлагын Удирдлагыг Бэхжүүлэх төсөл хэрэгжиж Монгол улсын ЭМҮТ-ны 1999-2002 оны үзүүлэлтийг толилуулж байсан.

Харин 2009-2011 онд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, 2012 оноос өнөөг хүртэл Дэлхийн эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй техникийн болон санхүүгийн туслалцааны үр дүнд 2017 онд Монгол улсын ЭМҮТ-ны 2003-2014 оны үзүүлэлтийг гаргаж дуусах шатандаа явж байна.

ЭМҮТ-ны систем нь олон улсад шинэчлэгдэж, улс орнууд шинэчилсэн систем рүү шилжиж байна. Цаашид Монгол улс шинэчлэгдэж буй системийн дагуу ЭМҮТ-ны үзүүлэлтийг өвчлөлөөр тооцдог болж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүнг бодлого төлөвлөлтөнд ашигладаг болоход Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын техникийн болон санхүүгийн туслалцааг авч үндэсний багийн чадавхийг сайжруулах шаардлагатай байна.

**Зорилго**

1. ЭМҮТ-ны шинэчлэгдсэн системийг ЭМҮТ-ны мэргэжилтнүүд болон холбогдох хүмүүст танилцуулах сургалт хийх
2. ЭМҮТ-ны талаар ерөнхий ойлголт, ач холбогдол, үр дүнг бодлого, шийдвэр гаргахад хэрхэн ашиглах талаар шийдвэр гаргагчдад танилцуулах
3. ЭМҮТ-ны 2015, 2016 оны мэдээллийг stata болон НАРТ програм хангамжийг ашиглан боловсруулахад ЭМҮТ-ны мэргэжилтнүүдийг дадлагажуулах

**Хугацаа:** 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 19-ний хооронд 8 өдөр

**Хүлээгдэж буй үр дүн:**

1. ЭМҮТ-ны мэргэжилтнүүд болон холбогдох хүмүүс ЭМҮТ-ны шинэчлэгдсэн системийн талаар нэгдсэн ойлголттой болсон байна.
2. Бодлого, шийдвэр гаргагчид ЭМҮТ-ны талаар ерөнхий ойлголттой болсон байна.
3. ЭМҮТ-ны мэргэжилтнүүд мэдээлэл боловсруулах дадлага эзэмшсэн байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Өдөр	Үйл ажиллагаа	Оролцогчид
1	2017.12.11	<ul style="list-style-type: none"> <li>Монгол улсын ЭМҮТ-ны 2003-2014 оны үзүүлэлт тооцсон ерөнхий аргачлалтай танилцах</li> <li>2017.12.12-ны өдөр зохион байгуулагдах ЭМҮТ-ны 2003-2014 оны үр дүнг танилцуулах болон бодлого шийдвэр гаргагчдад ЭМҮТ-ны талаар ерөнхий ойлголт өгөх танилцуулах уулзалтад бэлтгэх</li> </ul>	ЭМҮТ—ны мэргэжилтнүүд болон бусад холбогдох хүмүүс
2	2017.12.12	<ul style="list-style-type: none"> <li>ЭМҮТ-ны талаар ерөнхий ойлголт, ач холбогдол, үр дүнг бодлого, шийдвэр гаргахад хэрхэн ашиглах талаар шийдвэр гаргагчдад танилцуулах</li> <li>НАРТ программ хангамжийн талаар ЭМҮТ-ны мэргэжилтнүүдэд танилцуулах</li> </ul>	Бодлого, шийдвэр гаргагчид, ЭМҮТ—ны мэргэжилтнүүд болон бусад холбогдох хүмүүс
3	2017.12.13	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэндийн тооцооны систем-2011-ийн ерөнхий өөрчлөлтийн талаар ЭМҮТ-ны мэргэжилтнүүдэд танилцуулах сургалт (Эрүүл мэндийн зардлыг өвчлөлөөр хуваарилах)</li> <li>Өвчлөлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх дадлага</li> </ul>	ЭМҮТ—ны мэргэжилтнүүд болон бусад холбогдох хүмүүс
4	2017.12.14	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэндийн тооцооны систем-2011-ийн ерөнхий өөрчлөлтийн талаар ЭМҮТ-ны мэргэжилтнүүдэд танилцуулах сургалт (Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ)</li> <li>Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлэлд дүн шинжилгээ хийх дадлага</li> </ul>	ЭМҮТ—ны мэргэжилтнүүд болон бусад холбогдох хүмүүс
5	2017.12.15	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэндийн тооцооны систем-2011-ийн ерөнхий өөрчлөлтийн талаар ЭМҮТ-ны мэргэжилтнүүдэд танилцуулах сургалт (Эрүүл мэндийн санхүүжилтийн схем)</li> <li>Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлэлд дүн шинжилгээ хийх дадлага</li> </ul>	ЭМҮТ—ны мэргэжилтнүүд болон бусад холбогдох хүмүүс
6	2017.12.16	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэндийн тооцооны систем-2011-ийн ерөнхий өөрчлөлтийн талаар ЭМҮТ-ны мэргэжилтнүүдэд танилцуулах сургалт (Эрүүл мэндийн санхүүжилтийн эх үүсвэр)</li> <li>Эрүүл мэндийн салбарын төсвийн гүйцэтгэлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх дадлага</li> </ul>	ЭМҮТ—ны мэргэжилтнүүд болон бусад холбогдох хүмүүс
7	2017.12.18	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэндийн тооцооны систем-2011-ийн ерөнхий өөрчлөлтийн талаар ЭМҮТ-ны мэргэжилтнүүдэд танилцуулах сургалт (Тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага)</li> <li>Эрүүл мэндийн салбарын төсвийн гүйцэтгэлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх дадлага</li> </ul>	ЭМҮТ—ны мэргэжилтнүүд болон бусад холбогдох хүмүүс
8	2017.12.19	<ul style="list-style-type: none"> <li>Донор байгууллагын мэдээлэлд дүн шинжилгээ хийх дадлага</li> <li>Хувийн даатгалын мэдээлэл дээр дүн шинжилгээ хийх дадлага</li> </ul>	ЭМҮТ—ны мэргэжилтнүүд болон бусад холбогдох хүмүүс

**ДЭМБ-ын зөвлөх Фе Вида Н.Ди-Лиачо 2017.12.11-19-ны өдрүүдэд ЭМҮТ-ны чиглэлээр үзүүлэх зөвлөх үйлчилгээний хүрээнд хийх сургалтын төсөв**

Зардлын зүйл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Шинэчлэн боловсруулагдсан "Эрүүл мэндийн тооцооны систем-2011"-ийг ашиглан эрүүл мэндийн нийт зардлын тооцоолол хийхэд багийн чадавхыг бэхжүүлэх сургалт явуулах				
Цайны зардал	Хүн*удаа*өдөр	13 хүн * 1удаа * 6 өдөр	5,000	390,000
Үдийн хоол	Хүн * өдөр	13 хүн * 6 өдөр	15,000	1,170,000
Орчуулгын хөлс	цаг * өдөр	3 цаг * 6 өдөр	60,000	1,080,000
Бодлого болосвруулагч, шийдвэр гаргагчдад ЭМҮТ-ны талаар ерөнхий танилцуулга хийх				
Цайны зардал	Хүн*удаа	40 хүн * 1удаа	5,000	200,000
Орчуулгын хөлс	цаг	2 цаг	60,000	120,000
Бичиг хэргийн зардал (урилга хэвлүүлэх)				210,000
<b>Нийт</b>				<b>3,170,000</b>

Хянасан:



Д.Гантуяа /Ерөнхий ня-бо/

Боловсруулсан:

Т.Өнөрцэцэг /ЭМҮТ хариуцсан ахлах мэргэжилтэн/